



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/622 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Тариф батлах тухай” 444 дүгээр тогтоолын хавсралтын 1 болон 2 дахь хэсгийн 3 дугаар мөрний “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны энерги болон чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг хавсралтаар тус тус өөрчилсүгэй.

2. Өөрчлөгдсөн тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Амгалан дулааны станц” ТӨХК (М.Мөнхөө), “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК (Г.Баярсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Тариф батлах тухай” 444 дүгээр тогтоолын хавсралтын 1 болон 2 дахь хэсгийн 1, 2 дугаар мөр, 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Тарифт өөрчлөлт оруулах тухай” 228 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



Э.ТҮВШИНЧУЛУУН


П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн
19 дүгээр тогтоолын хавсралт



**“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ДУЛААН ХУДАЛДАХ ТАРИФ**

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны тариф (НӨАТ-гүй)-ыг
төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Төрөл	Хэмжих нэгж	Тариф
"УБДС" ТӨХК-д худалдах дулааны тариф			
1	Энергийн тариф	төг/ГЖ	6,220.00
2	Чадлын тариф		
	1 дүгээр улиралд	мян.төг/сар	4,225,494.00
	2 дугаар улиралд	мян.төг/сар	4,225,494.00
	3 дугаар улиралд	мян.төг/сар	1,668,018.00
	4 дүгээр улиралд	мян.төг/сар	1,668,018.00